

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/125/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2022 оны 02 дугаар сар</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: myangnboom@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт .....	16
4.2 Зөвлөмж .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/120

БАЯНГОВЬ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ц.БУЯНТОГТОХ ТАНАА

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

• 005020540

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is fluid and extends across the stamp.

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>135,159,778.32</b>	<b>111,706,180.10</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	11,116,412.00	7,362,997.09
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	890,465.00	7,362,997.09
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	10,225,947.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	10,225,947.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	124,043,366.32	104,343,183.01
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	10,687,200.00	14,149,561.40
35110	Тусгай зориулалттай материал	10,687,200.00	14,149,561.40
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	25,000,000.00	25,000,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	173,700.00	189,650.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	88,182,466.32	65,003,971.61
35410	Бичиг хэргийн материал	1,744,570.00	1,937,900.00
35420	Аж ахуйн материал	69,857,496.32	40,016,954.61
35450	Барилгын засварын материал	11,913,000.00	11,951,000.00
35460	Хүнсний материал	00.00	7,895.00
35470	Бусад хангамжийн материал	4,667,400.00	11,090,222.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,298,141,803.12</b>	<b>1,299,546,698.87</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,298,141,803.12	1,299,546,698.87
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,280,645,803.12	1,282,050,698.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,183,417,394.47	1,183,417,394.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	-55,991,623.00	-88,854,332.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	171,440,633.07	209,755,633.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	-120,805,776.83	-141,920,203.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	117,704,215.11	150,425,515.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	-68,042,660.57	-81,365,199.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,735,903.98	38,735,903.98
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,977,220.32	-11,743,650.48
39217	Ном	22,164,937.21	23,599,637.21
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	17,496,000.00	17,496,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,496,000.00	17,496,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,433,301,581.44</b>	<b>1,411,252,878.97</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>562,156.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	562,156.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	562,156.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	535,156.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	27,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,433,301,581.44</b>	<b>1,410,690,722.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,433,301,581.44	1,410,690,722.97
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	319,214,873.32	319,214,873.32
51101	Өмч: - төрийн	319,214,873.32	319,214,873.32
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	213,250,097.40	190,639,238.93
51210	Өмнөх үеийн үр дүн	213,250,097.40	213,250,097.40
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-22,610,858.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	900,836,610.72	900,836,610.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,433,301,581.44</b>	<b>1,411,252,878.97</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,082,557,421.61</b>	<b>975,247,634.40</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>32,469,903.61</b>	<b>24,474,571.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	32,469,903.61	24,474,571.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	30,329,803.61	24,474,571.40
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30,329,803.61	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан - Үндсэн хөрөнгө		16,770,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан - Бараа материал	00.00	7,704,571.40
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,052,218,618.00</b>	<b>950,773,063.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	911,478,000.00	825,998,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	911,478,000.00	825,998,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	46,879,118.00	28,035,733.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,748,018.00	28,035,733.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,131,100.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	93,861,500.00	96,738,630.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,861,500.00	96,738,630.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,014,265,394.98</b>	<b>992,918,492.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,014,265,394.98</b>	<b>992,918,492.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	899,838,726.98	912,465,593.07
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>593,267,660.10</b>	591,292,251.22
210101	Үндсэн цалин	412,049,984.10	591,292,251.22
210102	Нэмэгдэл	135,270,581.00	00.00
210104	Урамшуулал	45,947,095.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>78,447,098.49</b>	75,851,014.89
210201	Тэтгэврийн даатгал	58,235,728.43	51,010,139.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,694,882.06	6,837,212.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,814,273.25	4,801,048.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,422,180.61	1,200,233.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,280,034.14	12,002,382.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	90,659,067.00	95,738,630.00
210301	Гэрэл, цахилгаан	2,901,257.00	3,736,570.00
210302	Түлш, халаалт	86,657,810.00	90,902,060.00
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	1,100,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,306,931.30	46,913,852.71
210401	Бичиг хэрэг	3,216,270.00	5,344,163.00
210402	Тээвэр, шатахуун	5,072,625.00	2,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,533,000.00	2,218,600.00
210404	Ном, хэвлэл	3,411,100.00	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	655,000.00	690,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	4,243,250.00
210408	Бараа материал акталсны зардал	12,418,936.30	32,117,839.71
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	33,721,050.00	28,079,940.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	30,100.00
210502	Хоол, хүнс	31,284,950.00	23,087,900.00

**Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,436,100.00	4,961,940.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,069,700.00</b>	<b>1,615,000.00</b>
210604	Урсгал засвар	4,069,700.00	1,615,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,094,000.00</b>	<b>1,108,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,094,000.00	1,108,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,265,315.00</b>	<b>800,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,815,315.00	300,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>69,007,905.09</b>	<b>71,066,104.25</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	120,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	68,887,905.09	71,066,104.25
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>114,426,668.00</b>	<b>80,452,899.80</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>60,921,718.00</b>	<b>48,041,340.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	713,520.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,580,900.00	23,537,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,739,748.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,008,270.00	23,977,940.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	879,280.00	526,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>342,433.00</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	342,433.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>53,162,517.00</b>	<b>32,411,559.80</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,162,517.00	32,411,559.80
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>68,292,026.63</b>	<b>-17,670,858.47</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>4,940,000.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	4,940,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-4,940,000.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>68,292,026.63</b>	<b>-22,610,858.47</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,873.32	935,311,610.72	110,483,070.77	1,365,009,554.81
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	34,475,000.00	34,475,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	319,214,873.32	935,311,610.72	144,958,070.77	1,399,484,554.81
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	-34,475,000.00	00.00	-34,475,000.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	68,292,026.63	68,292,026.63
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,873.32	900,836,610.72	213,250,097.40	1,433,301,581.44

**Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	319,214,873.32	900,836,610.72	213,250,097.40	1,433,301,581.44
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	319,214,873.32	900,836,610.72	213,250,097.40	1,433,301,581.44
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-24,356,971.25	-24,356,971.25
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,873.32	900,836,610.72	188,893,126.15	1,408,944,610.19

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,052,227,618.00</b>	<b>953,512,379.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,140,100.00</b>	<b>2,739,316.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,140,100.00	2,739,316.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,140,100.00	2,739,316.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,140,100.00	2,739,316.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,050,087,518.00</b>	<b>950,773,063.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	911,478,000.00	825,998,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>44,748,018.00</b>	<b>28,035,733.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,748,018.00	28,035,733.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>93,861,500.00</b>	<b>96,738,630.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,861,500.00	96,738,630.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>999,090,718.00</b>	<b>909,121,379.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>999,090,718.00</b>	<b>909,121,379.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>884,259,250.00</b>	<b>828,476,529.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>593,085,905.00</b>	<b>605,656,135.21</b>
210101	Үндсэн цалин	411,868,229.00	410,690,774.00
210102	Нэмэгдэл	135,270,581.00	150,371,923.21
210104	Урамшуулал	45,947,095.00	44,593,438.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>80,451,213.00</b>	<b>69,887,875.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	57,735,196.00	52,305,492.31
210202	Тэтгэмжийн даатгал	7,290,817.00	5,164,332.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,925,700.00	4,142,876.92
210204	Ажилгүйдлийн даатгал	1,110,800.00	752,324.01
210205	Эрүүл мэндийн даатгал	10,388,700.00	7,522,850.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>90,519,067.00</b>	<b>95,738,630.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,951,257.00	3,736,570.00
210302	Түлш, халаалт	86,467,810.00	90,902,060.00
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	1,100,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,853,730.00</b>	<b>9,318,300.00</b>
210401	Бичиг хэрэг	1,369,100.00	1,347,800.00
210402	Тээвэр, шатахуун	5,100,000.00	2,100,000.00

**Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,703,000.00	1,719,500.00
210404	Ном, хэвлэл	3,607,100.00	300,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	575,000.00	1,471,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,499,530.00	2,380,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>45,652,065.00</b>	<b>28,060,295.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,004,500.00	2,494,100.00
210502	Хоол, хүнс	31,143,865.00	23,095,795.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,503,700.00	2,470,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>35,969,700.00</b>	<b>3,459,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,400,000.00	00.00
210604	Урсгал засвар	32,569,700.00	3,459,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,094,000.00</b>	<b>580,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,094,000.00	580,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,806,700.00</b>	<b>5,246,993.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,356,700.00	4,508,993.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	238,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>17,826,870.00</b>	<b>10,528,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,650,000.00	7,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,176,870.00	3,528,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>114,831,468.00</b>	<b>80,644,849.80</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>61,326,518.00</b>	<b>48,233,290.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,865,700.00	23,553,350.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	44,748,018.00	23,977,940.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,712,800.00	702,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>342,433.00</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	342,433.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>53,162,517.00</b>	<b>32,411,559.80</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,162,517.00	32,411,559.80
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>53,136,900.00</b>	<b>44,391,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>53,136,900.00</b>	<b>44,391,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>53,136,900.00</b>	<b>44,391,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>53,136,900.00</b>	<b>44,391,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	53,136,900.00	44,391,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-53,136,900.00</b>	<b>-44,391,000.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	926,802,700.00	890,325,770.20	36,476,929.80	96.06
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	926,802,700.00	890,325,770.20	36,476,929.80	96.06
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	897,412,200.00	866,070,420.20	31,341,779.80	96.51
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	614,702,200.00	602,916,819.21	11,785,380.79	98.08
210101	Үндсэн цалин	431,787,300.00	407,951,458.00	23,835,842.00	94.48
210102	Нэмэгдэл	137,202,600.00	150,371,923.21	(13,169,323.21)	109.60
210104	Урамшуулал	45,712,300.00	44,593,438.00	1,118,862.00	97.55
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	76,244,900.00	69,887,875.99	6,357,024.01	91.66
210201	Тэтгэврийн даатгал	54,382,700.00	52,305,492.31	2,077,207.69	96.18
210202	Тэтгэмжийн даатгал	5,465,600.00	5,164,332.11	301,267.89	94.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,372,400.00	4,142,876.92	229,523.08	94.75
210204	Ажилгүйдлийн даатгал	1,093,200.00	752,324.01	340,875.99	68.82
210205	Эрүүл мэндийн даатгал	10,931,000.00	7,522,850.64	3,408,149.36	68.82
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	99,804,000.00	95,738,630.00	4,065,370.00	95.93
210301	Гэрэл, цахилгаан	4,142,300.00	3,736,570.00	405,730.00	90.21
210302	Түлш, халаалт	94,561,700.00	90,902,060.00	3,659,640.00	96.13
210303	Цэвэр, бохир ус	1,100,000.00	1,100,000.00	-	100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,739,300.00	23,729,300.00	10,000.00	99.96
210401	Бичиг хэрэг	1,348,700.00	1,347,800.00	900.00	99.93
210402	Тээвэр, шатахуун	2,100,000.00	2,100,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,719,500.00	1,719,500.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	1,734,800.00	1,734,700.00	100.00	99.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,480,000.00	1,471,000.00	9,000.00	99.39
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,356,300.00	15,356,300.00	-	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	36,721,200.00	28,060,295.00	8,660,905.00	76.41
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,498,400.00	2,494,100.00	4,300.00	99.83
210502	Хоол, хүнс	31,751,500.00	23,095,795.00	8,655,705.00	72.74
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,471,300.00	2,470,400.00	900.00	99.96
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	33,459,800.00	33,439,800.00	20,000.00	99.94
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
210602	Тавилга	20,000,000.00	19,980,000.00	20,000.00	99.90
210604	Урсгал засвар	3,459,800.00	3,459,800.00	-	100.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	580,400.00	580,000.00	400.00	99.93
210702	Дотоод албан томилолт	580,400.00	580,000.00	400.00	99.93
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,481,600.00	1,189,200.00	292,400.00	80.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	741,600.00	451,200.00	290,400.00	60.84
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	238,000.00	2,000.00	99.17
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10678800.00	10528500.00	150,300.00	98.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00	7,000,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,678,800.00	3,528,500.00	150,300.00	95.91

**Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	29390500.00	24255350.00	5,135,150.00	82.53
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	29,390,500.00	24,255,350.00	5,135,150.00	82.53
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,688,300.00	23,553,350.00	5,134,950.00	82.10
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	702,200.00	702,000.00	200.00	99.97
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	926,802,700.00	890,325,770.20	36,476,929.80	96.06
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	825,998,700.00	793,587,140.20	32,411,559.80	96.08
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	825,998,700.00	793,587,140.20	32,411,559.80	96.08
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	100,804,000.00	96,738,630.00	4,065,370.00	95.97
132001	Орон нутгийн төсвөөс	100,804,000.00	96,738,630.00	4,065,370.00	95.97
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	49.00	49.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	36.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	-	100.00
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	49.00	49.00	-	100.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	30.00	30.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19.00	19.00	-	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>28,035,733.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>28,035,733.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	28,035,733.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,057,793.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,057,793.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	23,977,940.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	23,977,940.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,977,940.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	28,035,733.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,035,733.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын

31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, ковидын тест олгосон анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргах, Төсвийн тухай болон Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах зэрэг зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 46 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Ц.Буянтогтох, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Золжаргал нар зурж, нярваар 2021 оны 2021.01.01-2021.03.31 хүртэлх хугацаанд Д.Пүрэвдорж, 2021.04.01-2021.12.31 хүртэлх хугацаанд Д.Уранчимэг ажиллажээ.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль нийт 483 сурагчтай, баг анги, дунд анги гэсэн 2 заах аргын нэгдэл, захиргаа аж ахуйн нэгж гэсэн бүтэц зохион байгуулалттай 49 орон тоотой үйл ажиллагааг явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг 2019 онд батлан мөрдөж байсан ба 2021 онд аймгийн хэмжээнд мөрдөгдөх 300.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй, бусад хяналт шалгалтын байгууллагуудаас шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 1,014,265.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,142.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,606.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн Ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 976,666.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,938.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,453.7 мянган төгрөг байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,411,252.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 22,048.7 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	135,159.8	111,706.2	(23,453.6)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	11,116.4	7,363.0	(3,753.4)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	124,043.4	104,343.2	(19,700.2)
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,298,141.8	1,299,546.7	1,404.9
Үндсэн хөрөнгө	1,551,409.1	1,623,880.1	72,471.0
Хуримтлагдсан элэгдэл	(253,267.3)	(324,333.4)	(71,066.1)

**Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Нийт хөрөнгө	1,433,301.6	1,411,252.9	(22,048.7)
Өр төлбөр	-	562.2	562.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,433,301.6	1,410,690.7	(22,610.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,433,301.6	1,411,252.9	(22,048.7)

*Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан*

Тус байгууллагын төрийн сан банкны харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд ухаалаг самбарын 9,950.0 мянга, нийгмийн даатгалын 890.5 мянга, хувь хүний орлогын албан татварын 275.9 мянга, нийт 11,116.4 мянган төгрөгийн авлагатай байсныг бүрэн барагдуулсан байна. Сумын төрийн сангийн төлөөлөгч 2021.12.15-ний өдөр 7,202.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг шилжүүлэх төлбөрийн хүсэлтийг 2 удаа шивж оруулснаас энэ хэмжээгээр оны эцэст авлага үүссэн байна.

Оны эхэнд 124,043.4 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 74,948.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 7,704.6 мянган төгрөгийн бараа материал авч, 65,295.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, Төрийн аудитын газрын зөвлөмжийн дагуу 4,940.0 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгөд шилжүүлж, байгууллагын даргын 2021.12.31-ний өдрийн 60 дугаар тушаалаар 118 нэр төрлийн 32.117.839 төгрөгийн бараа материалыг актлан оны эцэст 104,343.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарчээ.

Оны эхэнд бүртгэлтэй 1,551,409.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж өмнөх онд авлагыг барагдуулан 9,950.0 мянган төгрөгийн ухаалаг самбарыг авч, төсвийн хөрөнгөөр 44,391.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, 4,940.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг аудитын зөвлөмжийн дагуу үндсэн хөрөнгөд бүртгэн, аймгийн ЗДТГ, “Дэлхийн зөн” олон улсын байгууллагаас 13,190.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй ирснийг бүртгэн, оны эцэст 1,623,880.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 23,520.9 мянган төгрөгөөр буурч 189,729.2 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү, өмнөх үеийн үр дүн данс өөрчлөлт ороогүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль 2021 оны төсвийн төлөвлөлтийг 1,100,052.0 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802, 71806 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэх төсвийг анх 864,317.6 мянган төгрөгөөр баталж, 2021 оны 7 дугаар сард 908,519.2 мянга, 12 дугаар сард 908,519.2 мянга, 11 дүгээр сард 926,802.7 мянган төгрөг болж, анх батлагдсан төсвөөс 62,485.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль өөрийн орлогын төлөвлөгөөгүй, тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих 825,998.7 мянган төгрөгийг бүрэн авснаас 32,411.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, орон нутгийн санхүүжилтээс олгох тогтмол зардлын санхүүжилтэд батлагдсан 100,804.0 мянган төгрөгөөс 4,065.4 мянган төгрөг дутуу буюу 96,738.6 мянган төгрөгийг авч, нийт 890,325.8 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 28,035.7 мянган төгрөг төвлөрч зарцуулснаас 23,977.9 мянган төгрөг нь 5 багшийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, 3,851.0 мянган төгрөг нь аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас олгосон “Номын богц” төслийн санхүүжилт, 206.8 мянган төгрөг нь Боловсролын үнэлгээний төвийн шалгалтын бичиг хэргийн зардал байна.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр дотуур байрны модон тавилга авах, камер суурилуулахад 23,745.0 мянга, ном худалдан авахад 1,434.7 мянга, сургалтын үйл ажиллагаанд 15,211.3 мянга, үдийн хоол хөтөлбөр хэрэгжихтэй холбоотой 4,000.0 мянга, нийт 44,391.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

## **3.8 Аудитын гол асуудал**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2021 онд нийт 10 бүлэг зорилтын хүрээнд 59 арга хэмжээг төлөвлөн ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг дарга “А” гэж дүгнэсэн байна.

## **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд

хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх Ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг шалгав.

Тус байгууллага нь 2021 онд нийт 1,142,983.3 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс 1,137,197.9 мянган төгрөгийн 106 мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлж, 2021.11.29-ний өдөр үдийн цайны зардалд "Мөнхөд дэлгэрэх" ХХК-д шилжүүлсэн 5,785.4 мянган төгрөгийн зарлагыг мэдээлээгүй орхигдуулсан зөрчил илэрсэнд менежментийн захидлаар зөвлөмж өглөө.

### **3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Бичиг хэргийн зардалд батлагдсан батлагдсан 1,834.8 мянган төгрөгийг бүрэн зарцуулж Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.9 дэх "Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах"
2. Тогтмол зардалд 99,804.0 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 95.9 хувь буюу 95,738.6 мянган төгрөгийг зарцуулан тогтоолын 1.8 дахь "Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, 2,486.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 8,572.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 4,119.4 мянган төгрөгийн зөвлөмж өгснийг бүрэн биелүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 22,022.6 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, санхүүгийн тайланд 836.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 7,363.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 13,823.6 мянган төгрөгийн 4 зөрчилд менежментийн захидлаар зөвлөмж хүргүүлэв.

### **4.1 Залруулсан алдаа**

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд дараах алдааг залруулав.

1. Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 836.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 836.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж залруулав.

#### 4.2 Төлбөрийн акт

1. Сумын төрийн сангийн төлөөлөгчийн буруугаас 2021.12.15-ний өдрийн нийгмийн даатгалын шимтгэлийн гүйлгээг давхардуулан оруулснаас оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын хэмнэлтийг төсөвт төвлөрүүлэлгүй, төвлөрсөн санд шилжүүлж, 7,362.9 мянган төгрөгийн авлага үүссэн байгаа тул дээрх нэмж залруулсан авлагатай нийлүүлэн төлбөрийн акт тогтоов.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын 7,362.9 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Зардлын холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Бичиг хэргийн зардалд батлагдсан батлагдсан 1,834.8 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан, тогтмол зардалд 99,804.0 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 95.9 хувь буюу 95,738.6 мянган төгрөгийг зарцуулан Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8, 1.9 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах

##### 2. Зардлын холбоотой асуудал

2.1. **Илрүүлэлт:** Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2021.11.29-ний өдөр “Мөнхөд дэлгэрэх” ХХК-д үдийн цайны зардалд шилжүүлсэн 5,785.4 мянган төгрөгийн зарлагыг мэдээлээгүй орхигдуулсан байна.

2.2. **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлэх.

##### 3. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

3.1. **Илрүүлэлт:** Оны эцэст байгууллагын даргын 54 дүгээр тушаалаар байгууллагын бүх албан хаагчдад ур чадварын нэмэгдлийг 25 хувиар хавтгайруулан олгож, 8,038.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.2. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж, цаашид алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах.

##### 4. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Тайлант онд зарцуулсан ковидын тестийн зарцуулалтыг сургуулийн эмч бүрэн хөтлөөгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, ковидын тест олгосон анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Залруулга				Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянговь сумын сургууль	6	22,022.6	1	836.00	1	7363.0	0	-	4	13,823.6

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---